

Батлав “БИ ТИ ЖИ ТИ” ХХК

Захирал: Д.Гантулга

Батлав “.....”

Захирал: /

Улаанбаатар хот

№SA19/

Огноо : 2020 оны сарын өдөр

Энэхүү гэрээг нэг талаас “.....” ХХК
РД: /цаашид “Худалдан авагч” гэх/-г
төлөөлж захирал, нөгөө талаас “БИ ТИ ЖИ
ТИ” ХХК /цаашид Худалдагч гэх/-г төлөөлж захирал Д.Гантулга, хамтад нь
“талууд” гэх/ нар Иргэний хуулийн 263 дугаар зүйлийг үндэслэн дараах
нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Худалдагч нь худалдан авагч талд тээврийн хэрэгслийн хяналтын төхөөрөмж /цаашид GPS гэх/-ийг 36 сар тасралтгүй ашиглах нөхцөлөөр зээлээр худалдах, худалдан авагч тал нь GPS-ийн үндсэн үнэ болон үйлчилгээний хөлсийг 36 сарын хугацаанд хэсэгчлэн төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2020 оны ___ сарын ___-ний өдрөөс эхлэн 2023 оны ___ дугаар сарын ___-ийг дуусгал 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.3 Энэхүү гэрээний хавсралт болон нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.
- 1.4 Гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон өдрөөс GPS худалдан авагчийн өмч болох бөгөөд талууд харилцан тохиролцож цаашид “Хяналтын програм ашиглах гэрээ” шинээр байгуулна.
- 1.5 Гэрээний дагуу худалдан авагч талд нийлүүлсэн програм хангамж болон тоног төхөөрөмжүүд түүний дагалдах хэрэгслүүд нь худалдагч талын өмч болно.
- 1.6 Гэрээ байгуулагдах үндэслэл:
 - Худалдан авагч талын хамтран ажиллах хүсэлт
 - Компанийн гэрчилгээ, Захирлын иргэний үнэмлэхний хуулбар
 - Худалдан авагч талын албан ёсны хаягийг нотлох баримт /үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагын тодорхойлолт, түрээсийн гэрээ/

ХОЁР. ТӨХӨӨРӨМЖИЙН БАТАЛГАА

- 2.1 Төхөөрөмжийн баталгаат хугацаа суурилуулан хүлээн өгөх акт үйлдсэнээс хойш 48 сар байна.
- 2.2 Доор дурдсан гэмтлүүд баталгаат хугацаанд хамаарахгүй:
 - Ослын улмаас тээврийн хэрэгсэл хэт хүчтэй доргисон, мөн бусад хүчин зүйлийн үйлчлэлээр төхөөрөмж, цохигдсон, хугарсан, утас тасарсан.
 - Цахилгааны хэт өндөр буюу 36 вольтоос дээш хэмжээний хүчдэлд санаатай болон санамсаргүй холбосон.
 - Ус болон бусад төрлийн шингэн зүйл хүргэж гэмтээсэн.
 - Сим картыг авч зориулалтын бусаар ашигласан.
 - Худалдагч талын оролцоогүйгээр GPS төхөөрөмжийг машинаас салгаж авсан.
 - GPS төхөөрөмжийн лацыг хөндсөн.
 - Гэрээ цуцлагдсан тохиолдолд баталгаат хугацаа хүчингүй.
- 2.3 Энэхүү гэрээний 2.2 дахь хэсэгт зааснаас бусад гэмтэл баталгаат хугацаанд хамаарах бөгөөд гэмтлийг Худалдагч тал бүрэн хариуцаж засварлах эсхүл ижил төрлийн шинэ төхөөрөмжөөр үнэ төлбөргүй сольж өгнө.
- 2.4 Шаардлагатай тохиолдолд автомашинд суурилагдсан GPS Төхөөрөмжийг худалдагч талын ажилтан шалгаж хэвийн ажиллагааг баталгаажуулж худалдан авагчаар гарын үсэг зуруулна.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ БА ҮНЭ

- 3.1 Энэхүү гэрээний зүйл нь тээврийн хэрэгслийн байршил заагч төхөөрөмж болон түүнийг хянах хяналтын програм байна.
- 3.2 Машины GPS төхөөрөмжийн нэг бүрийн үнэ **420,000₮ /дөрвөн зуун хорин мянган төгрөг/** байна. Нийт: ширхэг GPS төхөөрөмжийн дүн : төгрөг болно.
- 3.3 Машины GPS нэг бүрийг сар бүр **35,000₮ /цаашид “сарын суурь хураамж” гэх/** төгрөгийн үнээр **36 сар** тасралтгүй ашиглана. Тухайн сард хэдэн хоног ашигласнаас үл хамааран тогтмол байна.
- 3.4 Гэрээ байгуулснаас хойш GPS төхөөрөмж нэмж худалдан авсан бол баримтуудыг үндэслэн төлбөрийг шинэчлэн тогтоож хавсралт үйлдэнэ.
- 3.5 Гэрээний хугацаанд тасралтгүй 36 сарын туршид ашигласан тохиолдолд GPS худалдан авагчийн өмчлөлд шилжинэ.
- 3.6 Худалдан авагчийн эзэмшилд гэрээний зүйлийг шилжүүлэн хүлээлгэн өгсөн акт болон нэхэмжлэл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд Машины GPS төхөөрөмжийн үнэ төлөх **/сар бүр/** үндэслэл болно.
- 3.7 GPS төхөөрөмжийг өөр автомашинд шилжүүлэн суулгах ажлын хөлс **50,000₮ /Тавин мянган төгрөг/** байна.
- 3.8 Худалдан авагч тал нь гэрээний үнийг сарын бүрийн 5-нд багтаан худалдагч талын **ХААН** банкны **5007355133** тоот **Би Ти Жи Ти ХХК** данс руу шилжүүлнэ.
- 3.9 Гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд төлөөгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцох ба төхөөрөмжийн анхны үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

ДӨРӨВ. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ

- 4.1 Ажлын хөлс болон сарын суурь хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах
- 4.2 Төхөөрөмжийн баталгаат хугацаанд худалдан авагчтай тохиролцон үзлэг шалгалт хийх
- 4.3 Сарын суурь хураамж болон бусад төлбөрийг Худалдан авагч тал гэрээнд заасан хугацаанаас 10-аас дээш хоног хэтрүүлэн төлөөгүй тохиолдолд үйлчилгээг түр зогсоох, 30-аас дээш хоног төлөөгүй тохиолдолд гэрээг цуцлах, машины GPS төхөөрөмжийн анхны үнийг нэхэмжлэх
- 4.4 Худалдан авагч нь Улаанбаатар хотоос алслагдсан газар байрлаж буй тээврийн хэрэгсэлд төхөөрөмж суурилуулах, шинээр солих, засвар үйлчилгээ хийлгэхэд шаардагдах буудал, ажлын орчин нөхцөл, томилголт, тээврийн зардлыг Худалдан авагч талаар гаргуулах
- 4.5 Худалдан авагч тал нь 7.6, 7.7 заалтуудыг зөрчсөн 3.3, 3.2 д заасан тоног төхөөрөмжийн үндсэн төлбөр болон үйлчилгээний төлбөрийг нийт алдангийн хамт худалдан авагч талаас нэмэхжлэх эрхтэй.

ТАВ. ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ

- 5.1 Худалдагч тал нь Худалдан авагч талын мэдээлэл, тээврийн хэрэгслүүдийн байршил, статистик үзүүлэлтүүдийг бусдад дамжуулан задруулахгүй байх
- 5.2 Төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тасралтгүй хангах
- 5.3 Худалдан авагч талын удирдлага, жолооч, засварчид зэрэг шаардлагатай бүх ажилчдад төхөөрөмжтэй харилцах энгийн зөвлөгөө өгч, гарын авлагаар хангах
- 5.4 Энэхүү гэрээний 2.2 хэсэгт заасанаас бусад үндэслэлээр GPS эвдэрсэн, гэмтсэн нь тогтоогдвол шинэ төхөөрөмжөөр сольж өгөх. Тухайн төхөөрөмжийн эвдрэл гэмтлийн шалтгааныг худалдагч талын

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Худалдагч:
Албан тушаал:
Овог нэр:
Гарын үсэг:

Худалдан авагч:
Албан тушаал:
Овог нэр:
Гарын үсэг:

инженер болон худалдан авагч талын эрх бүхий албан тушаалтан хамтран тогтоох

- 5.5 Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд шаардагдах үүрэн холбооны дугаар, зарцуулагдах нэгж, сунгалт зэрэг зардлыг хариуцах.
- 5.6 Төхөөрөмжид гарсан аливаа гэмтэл доголдлыг Худалдан авагч тал мэдээлснээс хойш ажлын 2 хоногт багтаан бүрэн засварлах эсхүл шинэ төхөөрөмжөөр сольж өгөх

ЗУРГАА. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ

- 6.1 Гэрээний хугацаанд Худалдагчийн гэрээгээр хүлээсэн үүрэгт ажилд хяналт тавьж, доголдол гарсан тохиолдолд түүнийг арилгахыг шаардах
- 6.2 Гэрээ байгуулагдаж ажил эхэлснээс 30 хоногийн дотор Худалдагчийн буруугаас хяналтын программ хангамж болон төхөөрөмж ажиллахгүй байх, шаардлага хангахгүй байх тохиолдолд засварлах хугацааг тохиролцож заасан хугацаандаа хэвийн ажиллагаанд ороогүй тохиолдолд гэрээг дангаар цуцалж төлбөрийг Худалдагч талаас нэхэмжлэх
- 6.3 Төхөөрөмж болон програмд гарсан аливаа гэмтэл доголдлыг худалдагч талд мэдэгдэн яаралтай засуулах, дуудлага өгөх.

ДОЛОО. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ

- 7.1 Худалдагч талд төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх үүрэгтэй. Шилжүүлээгүй тохиолдолд гэрээнд заасан хохирол, алдангийг үл маргах журмаар барагдуулах
- 7.2 Улаанбаатар хотоос алслагдсан газарт тээврийн хэрэгсэлд төхөөрөмж суурилуулах, шинээр солих, засвар үйлчилгээ хийлгэхэд шаардагдах байрлах буудал, ажлын орчин нөхцөл, томилолт, тээврийн зардал зэргийг Худалдагч талд гаргаж өгөх
- 7.3 Төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, эвдэрч гэмтэхээс хамгаалах, лац хөндөхгүй байх, худалдагч талын инженерийн оролцоогүйгээр засварлах, задлахгүй байх
- 7.4 Гэрээний үүргийг худалдан авагчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхгүй байх
- 7.5 Худалдан авагч тал гэрээний нөхцөлийг бүрэн биелүүлэх боломжгүй буюу гэрээг цуцлах санал гаргасан тохиолдолд худалдагч талд учирсан хохирол, ажлын хөлс болон бусад холбогдох зардлуудыг худалдан авагч талд төлж барагдуулах үүргийг тус тус хүлээнэ.
- 7.6 Тоног төхөөрөмжийг гэрээний 3.3.д заасан 36 сарын хугацаанд тогтмол үйлчилгээний төлбөрийг төлж ашигласан тохиолдолд 3.2.т заасан төхөөрөмжийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. 3.3т заасан төлбөрийг төлөх боломжгүй болсон тохиолдолд бүх төхөөрөмжийг бүрэн бүтэн худалдагч талд хүлээлгэн өгөх үүрэг хүлээнэ.
- 7.7 Хэрэв гэрээгээр худалдан авсан бүх тоног төхөөрөмжийг бүрэн хүлээлгэж өгөөгүй тохиолдолд 3.2т заасан анхны үнийг бүрэн төлөх үүрэгтэй.

НАЙМ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 8.1 Гэрээний хугацаанд талууд тус бүр хүлээсэн үүрэг, эдлэх эрхийг гэрээн болон Монгол улсын бусад холбогдох хуулид заасны дагуу хэрэгжүүлнэ.
- 8.2 Төхөөрөмжийг зориулалтын бусаар буюу антинна таслах, засах, салгах гэж оролдох, гэжээлээс салгах тохиолдолд засварын хөлс болон торгуулийг худалдан авагч талаас нэхэмжилнэ. Торгууль нь тухайн төхөөрөмжийн үнийн дүнгийн 30 хувь байна.
- 8.3 Худалдан авагч төлбөр тооцоогоо цаг хугацаанд нь барагдуулаагүйгээс энэхүү гэрээний 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл байдал бий болж энэ хугацаанд худалдан авагч талд учирсан аливаа хохиролд худалдагч тал хариуцлага хүлээхгүй.
- 8.4 Худалдагч талаас шалтгаалахгүйгээр программ хангамжийн тасралтгүй ажиллагаанд нөлөөлөх, шилэн кабель тасалдах, цахилгаан доголдох, үүрэн холбооны сүлжээ тасалдах, гэмт халдлага, байгалийн

давагдашгүй хүчин зүйлээс үүссэн аливаа эрсдэлд талууд хариуцлага хүлээхгүй.

- 8.5 Худалдагч тал гэрээнээс үүдсэн хохиролд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй нэхэмжлэлийн шаардлагад дараах зүйлийг хамааруулан ойлгоно. Үүнд:
 - Улсын гэмдэгтийн хураамж
 - Өмгөөлөгчийн зардал
 - Төхөөрөмжийн ашигласан саруудын үйлчилгээний хөлс
 - Төхөөрөмж эргүүлэн авах шилжүүлэх зардал буюу ажлын хөлс

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй санал зөрөлдөөн, маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэх ба санал зөрөлдөөн, маргааныг эвийн журмаар шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд худалдагч талын харьяа шүүхэд хандан хэрэг маргааныг шийдвэрлүүлнэ.
- 9.2 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг аль нэг тал гаргавал нөгөө талдаа 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэний үндсэн дээр хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 9.3 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 9.4 Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагч, өмчлөгчид нь өөрчлөгдөх нь энэхүү гэрээг цуцлах, дуусгавар болгох талуудын аль нэгэнд хохирол учруулахуйц нөхцөл байдалд үр дүнд хүргэх үндэслэл болохгүй.
- 9.5 Энэхүү гэрээг хуулийн адил хүчин чадал бүхий 2 хувь үйлдэж талууд тус бүрд хадгалуулав.

АРАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 10.1 Гэрээг талуудын саналаар цуцлах, дуусгавар болгох тохиолдлуудад гэрээний зүйлийг буцаан авахад гарч буй ажлын хөлсийг худалдан авагч тал хариуцан барагдуулна
- 10.2 Худалдан авагч нь гэрээний үнэ болон сарын суурь хураамжийг төлөх чадваргүй болсон гэж үзэх үндэслэл тогтоогдвол гэрээг цуцалж худалдан авагч талаас хохирлоо нэхэмжилнэ.

Худалдан авагчийн мэдээлэл :

Компаний албан ёсны хаяг :

Утасны дугаарууд :

Компани гэрчилгээний хуулбар хавсаргах

Хяналтын програмд нэвтрэх мэдээлэл :

Програмын хаяг : www.mongolgps.com

Хэрэглэгчийн мэйл хаяг :

Нэвтрэх нэр :

Нууц код :

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Худалдагч:
Албан тушаал:
Овог нэр:
Гарын үсэг:

Худалдан авагч:
Албан тушаал:
Овог нэр:
Гарын үсэг: